

**Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын
жишиг сорил**

Хувилбар -6

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
 2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
 3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Буруу тодорхойлолтыг сонгоно уу
- A. Амьсгаадалт нь уушгины архаг бөглөрөлт өвчний үндсэн шинж мөн
 - B. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед амьсгаадалт зөвхөн ачааллын үед илэрнэ
 - C. Амьсгаадалт нь ихэнх өвчтөн эмнэлэгт хандах шалтгаан болдог
 - D. Амьсгаадалтын улмаас өвчтөн албадмал байрлалд орж болно
 - E. Амьсгалын замын халдвар амьсгаадалтыг сэдрээж болно
- /2./ Дараахаас аль нь уушгины архаг бөглөрөлт өвчний хүнд сэдэрэл үүсэх эрсдлийг нэмэгдүүлэх вэ?
1. Өндөр настай байх
 2. Хавсарсан өвчин эмгэгтэй байх
 3. Өвчин удаан хугацаанд үргэлжлэх
 4. Цэртэй ханиалгах
 5. Амьсгаадалт нэмэгдэх
- /3./ Уушгины архаг бөглөрөлт өвчний үед гуурсан хоолойн бөглөрөл үүсэх механизмыг нэрлэнэ үү:
1. Гуурсан хоолойн ханын үрэвсэл
 2. Цулцангийн ханын уян харимхай чанар буурах
 3. Гуурсан хоолой цэр, салсаар бөглөрөх
 4. Диффузлэх талбайн хэмжээ буурах
 5. Перибронхийн эдийн үрэвсэл
- /4./ Уушгинд тархмалаар хуурай хэржигнүүр сонсогдох шалтгааны:
1. Багтраа өвчин
 2. Уушгины хаван
 3. Уушгины архаг бөглөрөлт өвчин
 4. Уушгины фиброз
 5. Уушгины завсрын эдийн үрэвсэл
- /5./ Уушгины архаг бөглөрөлт өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү:
1. Тамхи
 2. Ажлын тоостой нөхцөл
 3. Агаарын бохирдол
 4. Амьсгалын замын цочмог халдвар
 5. Уушгины үрэвсэл
- /6./ Рестриктив хэлбэрийн агааржилтын дутагдлын үед уушгины агааржилтын ямар үзүүлэлт багасах нь ач холбогдолтой вэ?
- A. Амьсгалын эзлэхүүн

- В. Уушгины үлдэгдэл агаарын эзлэхүүн
 - С. Уушгины амьдралын багтаамж
 - Д. Уушгины нийт багтаамж
 - Е. Уушгины үйл ажиллагааны үлдэгдэл багтаамж
- /7./ Уушгины сүрьеэ үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бол:
- 1. Ходоод, дээд гэдэсний шархлаа
 - 2. Чихрийн шижин
 - 3. Силикоз
 - 4. Лимфогранулематоз
 - 5. Артерийн гипертензи
- /8./ Дараахас бусад нь багтраа өвчнийг тодорхойлно
- А. Багтрал вентолин цацлагаар хэрэглэхэд намдана
 - В. Цэрэнд Шарко-Лейдене талст илэрч болно
 - С. Уушгины эмфизем үүснэ
 - Д. Багтрал сунжрахад нойтон хэржигнүүр сонсогдоно
 - Е. Өвчин аль ч насанд үүсч болно
- /9./ Сүрьеэгий микобактерээр хүн халдварлах үндсэн зам бол
- А. Арьсаар
 - В. Хүнсээр
 - С. Ихсээр
 - Д. Агаар-дуслаар
 - Е. Салстаар
- /10./ Уушгины тархмал сүрьеэгийн үед хамгийн элбэг гэмтэх эрхтэн бол
- А. Яс
 - В. Бөөр
 - С. Гэдэс
 - Д. Дэлүү
 - Е. Серозон бүрхүүл
- /11./ Бөөр хамгаалах бэлдмэл болох лизиноприл ямар механизмаар үйлчилдэг вэ?
- 1. Цусны даралт бууруулах
 - 2. Түүдгэнцрийн дотоод даралт бууруулах
 - 3. Түүдгэнцрийн гипертрофиг багасгах
 - 4. Протейнуриг багасгах
 - 5. Мезангиаль эсийн өсөлтийг бууруулах
- /12./ БАӨ-ий 1-2р үе шатанд лабораторын шинжилгээгээр хянах үзүүлэлт
- 1. Шээсний хүчил
 - 2. Креатинин
 - 3. Электролит
 - 4. Өлөн үеийн сахар, липид
 - 5. ТШХ
- /13./ Шээсний шинжилгээнд ямар төрлийн бортгонцор илэрвэл хэвийн гэж үзэх вэ?
- А. Гиалин
 - В. Зернистый
 - С. Восковидный
 - Д. Эритроцитын
 - Е. Лейкоцитын
- /14./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.
- А. Бөөрний хавдар
 - В. Шалтгаан тодорхойгүй шээс цустах
 - С. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх
 - Д. Архаг гломерулонефрит
 - Е. Бөөрний унжилт
- /15./ Хоногийн шээсний хэмжээ 100 мл-ээс багасахыг юу гэж нэрлэх вэ ?
- А. Полиури
 - В. Никтири
 - С. Поллакури

- D. Дизури
- E. Анури

/16./ Нефрозийн кризийн гол шалтгаан

- A. Цусны даралт ихсэх
- B. Цустай шээх
- C. Хэт их хавагнах
- D. Зүрхний дутагдал
- E. Тархи хавагнах

/17./ Жирэмсний эрт үед пиелонефритын эмчилгээнд хэрэглэх эм

- A. Нитрофураны бүлэг
- B. Пенициллины бүлэг
- C. цефалоспорины бэлдмэлүүд
- D. Сульфаниламид
- E. Нитроксолины бүлэг

/18./ Гломерулонефрит үүсэхэд нөлөөлөх гадаад хүчин зүйлд

- 1. Сийвэн , эм ,химийн бодис
- 2. Зохисгүй хооллолт , архи ихээр хэрэглэх
- 3. Хорхой шавьжинд хазуулах
- 4. Т, В лимфоцитуудын хэвийн харьцаа алдагдах
- 5. Т лимфоцитын төрөлхийн болон олдмол дутмагшил

/19./ Шээсний нянгийн шинжилгээд дараах аргууд орно

- 1. Зимницкийн сорил
- 2. Бактерлогийн шинжилгээ
- 3. Бензолын сорил
- 4. Нитритийн сорил
- 5. Преднизолоны сэдээх сорил

/20./ Бөөрний хурц дутагдлын эрт үеийн үндсэн шинж тэмдэг нь

- 1. Олигоанури
- 2. Цилиндрури
- 3. Азотеми
- 4. Хаван
- 5. Гематури

/21./ хүүхэд жин багатай төрөх нь бөөрний архаг өвчний эрсдэлт хүчин зүйл болдог. Иймд Эхийн хоол тэжээлийн дуталыг шалтгааныг эрт илрүүлэн эмчилснээр үүнийг сэргийлэх боломжтой юм.

/22./ БАД-ын үед электролитын солилцоонд хямрал үүсч сийвэнгийн кали ихэсдэг тул 5%-ийн 100-200 мл глюкозын уусмалыг инсулины хамт судсаар тарина. Инсулин эсийн гаднах шингэний калийг эсийн дотор орох нөхцлийг бүрдүүлж цусан дахь калийн хэмжээ буурдаг.

/23./ Улаан хоолойн тархмал агшилт гэдэг нь:

- A. Улаан хоолойн доод хуниасны даралт хэвийн байхад улаан хоолойн гөлгөр булчин байнга тархмалаар агших
- B. Улаан хоолойн доод хуниасны даралт хэвийн байхад улаан хоолойн гөлгөр булчин үе үе тархмалаар агших
- C. Улаан хоолойн доод хуниасны даралт хэвийн байхад улаан хоолойн гөлгөр булчин байнга агших
- D. Улаан хоолойн доод хуниасны даралт их байхад улаан хоолойн гөлгөр булчин байнга агших
- E. Улаан хоолойн доод хуниасны даралт бага байхад улаан хоолойн гөлгөр булчин байнга агших

/24./ Цэсний чулуу хайлуулах мэс заслын бус эмчилгээ

- A. Уян дурангаар хийх холецистэктоми ажилбар
- B. Литотрипси, урсофальк
- C. Цэсний гэрийг магnezмаар угаах

- D. Зүү эмчилгээ
E. Хоолны дэг баримтлах
- /25./ Бүдүүн гэдэсний эмгэгийн үед ШЕШ-д ямар өөрчлөлт гардаг вэ?
A. Шээсний хувийн жин нэмэглэнэ
B. Лейкоцитын тоо олширно
C. Шээсний хүчил нэмэгдэнэ
D. Оксалат + кальцитай
E. Уураг алдагдах
- /26./ Сульфасалазин ямар үйлдэлтэй вэ.
A. Гэдэсний хөдөлгөөн зохицуулах
B. Эмгэг флорын ургалт саатуулна
C. Дархлаа дарангуйлна
D. Гэдэсний цусан хангамж сайжирна
E. Нянгийн ба үрэвслийн эсрэг үйлчилнэ
- /27./ Гиперспленизмтэй аль нь холбоогүй вэ.
A. Панцитопени
B. Спленомегали
C. Шарлалт
- /28./ Улаан хоолойн булчинлаг бүрхүүл нь хэдэн см зузаантай вэ?/
1. 0.7 см
2. 1.5 см
3. 1.0 см
4. 2.0 см
5. 2.5 см
- /29./ Н.рулоги устгах эмчилгээний үр дүнг тооцохын тулд ямар шинжилгээг эмчилсэнээс хэд хоногийн дараа хийвэл зохистой вэ?/
1. Дурангийн шинжилгээг 28 хоногийн дараа
2. Уреазын түргэвчилсэн сорилыг 24-28 хоногийн дараа
3. Баасанд антиген илрүүлэх шинжилгээг 28 хоногийн дараа
4. Амьсгалын сорилыг 14 хоногийн дараа
5. Молекулбиологийн шинжилгээг 24 хоногийн дараа
- /30./ Шархлаа өвчний эмгэг жамд ямар ямар үндсэн нөхцөлүүдийг онцлон үздэг вэ?/
1. Хамгаалах хүчин зүйл буурах
2. Салстын нөхөн төлжилт буурах
3. Дархлалын тогтолцоо алдагдах
4. Давсны хүчилийн ялгаралт ихсэх
5. Хөнөөх хүчин зүйл багасах
- /31./ Мезим форте эмийн найрлагад ямар фермент байдаг вэ?
1. Протеаз
2. Липаз
3. Амилаз
4. Трипсин
5. Мальтаз
- /32./ Бүдүүн гэдэсний салст бүрхүүлийн бүтцэд хамаарагдахгүй нь аль вэ?
1. Цэлмэнт эс
2. Хундган эс
3. Панетийн эс
4. Хучуур эс
5. Эндокрины эс
- /33./ Улаан хоолойн агчилийн үед идэж уусан зүйл улаан хоолойноос ходоод руу ороход саадтай болно. Учир нь доод хунигч булчин чангарч, рефлексээр онгойхоо больдог.
- /34./ Элгэн дэх холестаазын үед цөсний хүчлийн нийлэгжилт сулардаг. Учир нь элэгний эс гэмтсэнээс чөлөөт билирубиныг глюкуроны хүчилтэй холбох чадвар алдагдан цөсний пигмент үүсэх процесс саатдаг

- /35./ Гиперкортицизмын шалтгааныг нэрлэ
- A. Гүйлгэх
 - B. Глюкокортикойд эмчилгээг гэнэт хасах
 - C. Феохромоцитома
 - D. Аменоррей
 - E. Глюкокортикостерома
- /36./ Гипотиреозтой өвчтөнд илрэх зовиур
- A. Олигоаменоррей
 - B. Хэл яриа дультрах
 - C. Гар хөл салганах
 - D. Халууцаж хөлрөх
 - E. Гүйлгэх
- /37./ Гиперкортицизмын шалтгааныг сонгоно уу
- A. Тромбоз
 - B. Базофиль эсийн хавдар
 - C. Стресс
 - D. Глюкокортикоидын эмчилгээг таслах
 - E. Бөөрний дээд булчирхайн сүрьеэ
- /38./ Ясны нийт эзэлхүүний хэдэн хувийг ясны эс эзлэх вэ?
- A. 70%
 - B. 50%
 - C. 30%
 - D. 10%
 - E. 3%
- /39./ Бамбай булчирхайн томролын 2-р зэрэг гэдэг нь
- A. Харагдахгүй, тэмтрэгдэхгүй
 - B. Харагдахгүй, тэмтрэгдэнэ
 - C. Харагдана, тэмтрэгдэхгүй
 - D. Харагдана, тэмтрэгдэнэ
 - E. Дээрхийн аль нь ч биш
- /40./ Гипотиреозын үед даавар орлуулах эмчилгээнд хэрэглэдэг бэлдмэл
1. Тиреотом
 2. L-тироксин
 3. Трийодтиронин
 4. Преднизолон
 5. Гидрокортизон
- /41./ Гипотиреозидизмтэй өвчтөнд илрэх үндсэн зовиурт аль нь орохгүй вэ?
1. Турах
 2. Арьс хуурайших
 3. Гүйлгэх
 4. Хавагнах
 5. Даарах
- /42./ Гипокортицизмын өвчний үед арьсны язрал үүсдэг. Учир нь гипокортицизмын үед кортизол даавар ихэсдэг.
- /43./ Анхдагч артерийн гипертензийн эрсдлийн зэргийг тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ?
1. Онош тодруулах
 2. Тавиланг урьдчилан тодорхойлох
 3. Өвчтөнг үнэлэх
 4. Эмчилгээний тактикийг зөв сонгох
 5. Хүндрэлийг тодорхойлох
- /44./ ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээсийн үед цус алдах эрсдэл өндөр байвал ямар антикоагулянтийг хамгийн түрүүнд сонгох вэ?

- A. Бивалирудин
- B. Эноксипарин
- C. Фраксипарин
- D. Фондапаринукс
- E. Гепарин

/45./ Зүрхний шигдээстэй өвчтөнд яаралтай тусламж үзүүлэхдээ аспириныг ямар тунгаар өгөх вэ?

- A. 75-81мг
- B. 100 мг
- C. 162-325мг
- D. 500 мг
- E. 162-500мг

/46./ ST сегмент өргөгдсөн зүрхний шигдээстэй өвчтөнг эмнэлгээс гарсаны дараа ямар эмийн бэлдмэл хэрэглэхийг үндэсний удирдамжид зөвлөсөн байдаг вэ?

- 1. Аспирин
- 2. Метопролол
- 3. Каптоприл
- 4. Симвастатин
- 5. Томуугийн эсрэг вакцин

/47./ Зузааралтын кардиомиопати нь...

- 1. Удамшлын өвчин
- 2. Нитратын бэлдмэлээр эмчлэхэд үр дүнтэй
- 3. Бета хоригч хэрэглэхэд гэнэтийн нас баралтын эрсдлийг бууруулдаг
- 4. Зүрхний цахилгаан бичлэг нь эрт илрүүлэх гол арга мөн
- 5. Гэнэт нас барах эрсдэлтэй

/48./ Митрал хавхлагын нээлтийн талбайн хэвийн хэмжээг сонгоно уу?

- A. 2.0-2.5 см²
- B. 2.5- 3.0 см²
- C. 3.5 -4.0 см²
- D. 3.0-3.5 см²
- E. 4.0-6.0 см²

/49./ Аортын хавхлагын нарийслын үед толгой өвдөх, толгой эргэх, цээжээр өвдөх зэрэг шинж тэмдэг гардаг. Учир нь энэ гажгийн үед зүрхний минутын эзлэхүүн буурч, тархины болон зүрхний цусан хангамж багасдаг.

/50./ Зүрхний Дэлхийн Холбоо зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх гол арга замыг юу гэж тодорхойлсон вэ?

- A. Амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх
- B. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх
- C. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах
- D. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэн, тэдгээрийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах
- E. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдах

/51./ Гепариныг зүрхний цочмог шигдээсийн үед ямар үзүүлэлтээр хянаж хэрэглэдэг вэ?

- 1. Тромбины хугацаа
- 2. INR
- 3. Протромбины хугацаа
- 4. a PTT
- 5. Фибриноген

/52./ Артерийн гипертензийг цус хөдлөл зүйн хэлбэрээр ангилах нь ямар ач холбогдолтой вэ?

- A. Өвчний явцыг үнэлэх
- B. Ялган оношлох
- C. Тавиланг тодорхойлох
- D. Оношлох

Е. АД бууруулах эмийг зөв сонгох

/53./ Зүрхний багтрааны үед дараах арга хэмжээнүүдийн алийг нь хэрэглэх вэ ?

1. Фуросемидийг судсаар хийх
2. Эуфиллин тарих
3. Морфин тарих
4. Симпатомиметик тарих
5. бета блокатор хэрэглэх

/54./ Эххимоз гэдэг нь....

- A. 5 см болон түүнээс дээш диаметр хэмжээтэй, арьсны түвшингээс овойгоогүй
- B. Хэмжээний хувьд үзэгний үзүүр төдий олон тооны цусархаг тууралт
- C. Дотор эрхтний гаралтай цус алдалт
- D. 5 см хүртэлх диаметр хэмжээтэй, ихэвчлэн судас тойрон гардаг тууралт
- E. Цустай ханиах, цустай цэр гарах зэрэг амьсгалын эрхтэн системээс илрэх өөрчлөлт

/55./ Витамин В12 дутагдлын цус багадалтын эмчилгээнд В12 хэрэглэж эхэлсний дараахан доорх хүндрэл илэрч болно.

1. Сийвэнгийн ШФ ихсэх учир сийвэнгийн ШФ-г хянах нь зүйтэй.
2. Гипокальциеми болдог учир ийлдсийн кальцийн хэмжээг хянах нь зүйтэй.
3. Гипербилирубинеми болдог учир билирубиныг хянах нь зүйтэй.
4. Гипокалиеми болдог учир ийлдсийн калийн хэмжээг хянах нь зүйтэй
5. Сийвэнгийн фолийн хүчил ихсэх учир сийвэнгийн ФХ-г хянах нь зүйтэй

/56./ Аплазын цус багадалтын эмчилгээний төлөвлөгөөг бичнэ үү?

1. Дархлал дарангуйлах
2. Ясны хэм шилжүүлэн суулгах
3. Шинж тэмдгийн дэмжих эмчилгээ
4. Дэлүү авах
5. Эсийн өсөлтийг дэмжих

/57./ Эритропэтиний үйлдлийн механизмыг сонгоно уу?

- A. 5 метилтетрагидрофолатаас Тетрагидрофолат үүсгэж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд нөлөөлнө
- B. Гемийн бүтцэд орж гемоглобины нийлэгжилтийг дэмжинэ
- C. Улаан эсийн JAK2 ферментийг идэвхжүүлж эсийн хуваагдлыг дэмжинэ
- D. Тимидилат синтеза ферментийн бүрэлдэхүүнд орж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд оролцоно
- E. Тимидилат синтеза ферментийн бүрэлдэхүүнд орж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд оролцоно

/58./ Цусны хурц хавдарын ид үедээ оношлогдсон залуу насны хүнд ямар хими эмчилгээ сонгох вэ?

- A. Засралд хүргэх (индукц)
- B. Засралыг бэхжүүлэх (консолидац)
- C. Засралыг барих (поддержание)
- D. Гидреа өндөр тунгаах өгөх
- E. Монохими эмчилгээ хийх

/59./ Цочмог лимфобластын бус лейкозын үед хийгдэх хамгийн тохиромжтой хими эмчилгээний хөтөлбөрийг уялдуулан сонгоно уу

- A. Цитозар+6-меркаптопурин
- B. Винкристин+Рубомицин+Преднизолон+Л-аспарагиназа
- C. Винкристин+Цитозар+Рубомицин+Преднизолон
- D. Цитозар+Рубомицин
- E. Рубомицин+ Циклофосфамид+Метатрексат

/60./ Цочмог лейкеми эмгэгийн үед захын цусны шинжилгээнд голчлон илэрдэг өвөрмөц өөрчлөлтийг сонгоно уу

- A. Гумпрехтийн сүүдэр
- B. Базофиль-эозинофилийн холбоо
- C. Лейкемийн цонх
- D. Улаан эс нулимсны дусал хэлбэртэй болох
- E. Өрсөн зоосны шинж

- /61./ Жирэмсэн үед яагаад доод мөчдөөр хавагнах хандлагатай болдог вэ?
1. Томорсон умай доод хөндийн венийн судсыг дарснаас
 2. Цусны осмос даралт буурснаас
 3. Доод мөчдийн венийн судасны даралт нэмэгдсэнээс
 4. Биед натри хуримтлагдсанаас
 5. Альдостероны ялгарал нэмэгдсэнээс
- /62./ Тэмбүүгийн үед эмэгтэйд ямар эмчилгээ хийх вэ?
1. Бензатилпенициллин G тарина
 2. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух .
 3. Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух.
 4. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих.
 5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах
- /63./ Ураг орчмын шингэний бүрхүүл жирэмсний 33 долоо хоногоос дээш хугацаанд хагарсан бол ямар тусламж үзүүлэх вэ
1. Тохирох антибиотیکیг тарина
 2. . Антибиотик уулгана.
 3. "Умайн ба ургийн халдвар " гэж ангилаад эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
 4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна.
 5. Ношпа уулгана
- /64./ Ураг хөлөөр түрүүлсэн үед төрөх тасагт хэдэн долоо хоногтойд хэвтүүлэх вэ?
- A. 35-36 долоо хоногтойд
 - B. 38-39 долоо хоногтойд
 - C. 40 долоо хоногтойд
 - D. Хамааралгүй
 - E. Төрөлт эхлэнгүүт
- /65./ Хэвийн явцтай жирэмсэн үед биеийн жин хэрхэн нэмэгдэх вэ?
- A. 4-5 кг
 - B. 7-8 кг
 - C. 9-12 кг
 - D. 16-18 кг
 - E. 20-25 кг
- /66./ Ургийн хөдөлгөөн давтан төрөгч эмэгтэйд жирэмсний хэдэн долоо хоногтойд мэдрэгдэх вэ?
- A. 13 долоо хоногтойд
 - B. 18 долоо хоногтойд
 - C. 23 долоо хоногтойд
 - D. 24 долоо хоногтойд
 - E. 26 долоо хоногтойд
- /67./ Олонтой тохиолддог бамбай булчирхайн үрэвсэлт өвчнүүдэд дараах өвчнүүдээс аль нь хамаарах вэ?
- A. Хурц тиреоидит буюу струмит
 - B. Гүвгэр тиреоидит де Кервена- Крайл
 - C. Лифоматозон тиреоидит буюу Хашимот
 - D. Ширхэнцэрт Риделягийн тиреоидит
 - E. Гиперпаратиреоидизм
- /68./ Өрцний улаан хоолойн хажуугийн нүхний ивэрхийний үед рефлюкс-эозфагит ямархувиар тохиолддог вэ?
- A. Өвчтөнүүдийн 10-аасбага хувьд нь
 - B. Өвчтөнүүдийн 20-40 хувьд нь
 - C. Өвчтөнүүдийн 40-60 хувьд нь
 - D. Өвчтөнүүдийн 60-80 хувьд нь
 - E. Өвчтөнүүдийн 80-аас дээш хувьд нь
- /69./ Уушигны олон тооны цочмог буглааны эмийн эмчилгээний сайн үр дүн
- A. Эдгэрэлт
 - B. Хордлого тайлагдах
 - C. Өвчлөлийг архагт шилжүүлэх

- D. Үр дүн гарахгүй
- E. Шинж тэмдэг арилах

/70./ Амин эрхтэнд хамаарахыг нь сонгоно уу?

- 1. Амьсгалын зам
- 2. Амьсгалалт
- 3. Цус эргэлт
- 4. Элэг
- 5. Бөөр

/71./ Осолдсон хүнийг амь тэнссэн байдалд орсон эсэх үнэлгээнд хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?

- A. Осолдогчтой харилцаж, дуудах
- B. Ухаангүй байвал тусламж дуудах
- C. Амьсгалын замыг чөлөөлөх
- D. Амьсгалалтыг чагнах
- E. Цус алдаж байгаа эсэхийг шалгах

/72./ 82 настай эмээгийн дунд чөмөг хугарсан тул гэмтэлд очсон байв. Түүний яс хэтэрхий сийрэг тул хадаас тогтохгүй гээд гипс тавиад буцаажээ. Тэр 2 сар гэртээ хэвтэрт маш их өвдөлттэй байсан ба памперс солих үед уйлдаг байв. Түүний 7-9-р зэргийн өвдөлт 2 сарын турш намдаагүй ба хөлний яс байнга янгинах, хөдлөх үед хатгуулах зэргээр дуу алдам хүчтэй өвддөг байсан тул богино үйлчилгээтэй Морфины сульфатыг 10 мг-аар 6 цагаар ууж байсан. Түүнийг Фентанилын наалтаар солих бол ямар тунтай наалт хэрэглэх ба хэзээ, хэрхэн солих вэ?

1. Долфорин буюу Фентанилын 25 мкг/цаг наалтыг өвчтөний цээж, эсвэл бугуй, эсвэл нурууны дээд хэсгийн арьсан дээр наана

2. Долфорин буюу Фентанилын 50 мкг/цаг наалтыг өвчтөний арьсан дээр наана.

3. Долфорины наалт нааснаас 12 цагийн дараа Морфиныг хасна

4. Долфорин наасны дараа Морфиныг 6 цагийн дараа хасах хэрэгтэй

5. Долфорин наасны дараа Морфиныг 72 цагийн дараа хасах хэрэгтэй

/73./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, 2 сарын турш 200 мг-аар буюу 8 шахмалаар ууж, сүүлийн сар 80 мг Фуросемидтэй хавсарч уудаг байсан. Түүний асцит нэг хэсэг буурсан байснаа одоо дахин ихсэж эхлэв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

A. Спиринолактоныг дагаар нь 200- 300 мг-аар өглөө бүр уулгах

B. 200 мг Спиринолактоныг 80 мг Фуросемидтэй хавсарч уулгах.

C. Фуросемид дагаар нь 40 мг-аар уулгах

D. Фуросемид дангаар нь 80 мг-аар уулгах

E. Өвчтөнд зовиур ихтэй ба зөвшөөрч байвал парацентез хийх

/74./ Талбөмбөлгийн цус харвалтын эмчилгээний зарчим

1. Тархины мэс засал

2. Тархины хаванг бууруулах

3. Артерийн даралт хяналт

4. Амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг тогворжуулах

5. Хүчилтөрөгчөөр дэмжих

/75./ Хүний сэтгэхүй хэдээс хэдэн насны хооронд бүрэлдэн тогтдог вэ?

A. 20-25

B. 18-22

C. 22-25

D. 20-22

E. 18-25

/76./ Элгэнд хортой гаж урвал үүсгэх боломжтой сүрьеэгийн эмийн бэлдэмлүүдийг нэрлэнэ үү?

1. Изониазид

2. Рифамицин

3. Пиразинамид

4. Этамбутол

5. Стрептомицин

/77./ Сүрьеэгийн менингитийн үед нугасны усны шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тоочно уу?

- A. Уургийн хэмжээ ихсэх
- B. Эсийн тоо олшрох
- C. Сахарын хэмжээ буурах
- D. Хлоридын хэмжээ буурах
- E. Бүгд зөв

/78./ Уушгины гэрлийн шинжилгээнд уушигны ямар эмгэгийн үед цагираг сүүдрийн хам шинж илрэх вэ?

- 1. Гуурсан хоолойн гаралтай уулинхай
- 2. Хавдарын задрал
- 3. Хөндийт сүрьеэ
- 4. Уушгины голомтот сүрьеэ
- 5. Туберкулема

/79./ Нэвчдэст сүрьеэгийн хүндэрлийг нэрлэнэ үү?

- A. Сорвит голомт үүсэх
- B. Туберкулем үүсэх
- C. Хөндийт сүрьеэ үүсэх
- D. Тархмал сүрьеэ үүсэх
- E. Дээрхи бүгд

/80./ Бруцеллийн халдвар авсан болохыг илрүүлэх харшил сорил тавихад ашигладаг бодисыг тэмдэглэ.

- A. Дизоитерии
- B. Бруцеллин
- C. Антраксин
- D. Туберкулин
- E. Тулерин

/81./ Боом өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Спирохет
- B. Ортомиксовирус
- C. Рабдовирус
- D. Бацилла антрацис
- E. Реовирус

/82./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.

- 1. Өндөр настай хүмүүст
- 2. Хуурай хэлбэр
- 3. Жирэмсэн эмэгтэйд
- 4. Цахилгаан хэлбэр
- 5. Бага насны хүүхдэд

/83./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.

- 1. Нууц хугацаа 2-7 хоног
- 2. Ангина илрэхгүй
- 3. Тууралт нүүрнээс эхэлнэ
- 4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
- 5. Эрүүн дорхи лимфаденит болно

/84./ Цочмог дакриоаденит ямар өвчний дараа үүсдэг вэ?

- 1. Ханиад
- 2. Томуу
- 3. Ангин
- 4. Халдварт паротит
- 5. Балнад

/85./ Невритийн үед үүсэх шинж тэмдэгийг нэрлэнэ үү.

- 1. Харааны чадал буурах
- 2. Харааны талбай багасах
- 3. Өнгө таних чадвар багасна
- 4. Төвийн скотом үүснэ

5. Нүдний угт өвдөлт илэрнэ

/86./ Хоёр нүдний хугалах хүч адилгүй байхыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Гиперметропи
- B. Миопи
- C. Анизометропи
- D. Астигматизм
- E. Эмметропи

/87./ Нярай хүүхдэд хөхлөг сэртэн хөгжөөгүй байдаг (1). Хүүхэд өсөхийн хирээр хүзүү толгойн булчин хөгжиж, толгойгоо дааж ирэхэд хөхлөг сэртэн хөгжиж ирнэ

/88./ Төвөнх хаана оршдог эрхтэн бэ?

- A. Хэлэн доорхи яс болон цагаан мөгөөрсөн хоолойн хооронд
- B. Хэлэн доорхи ясны доор, хүзүүнд
- C. Хэлэн доорхи ясны доор, хүзүүний 2-4-р нугалмын харалдаа
- D. Хэлэн доорхи яс болон цагаан мөгөөрсөн хоолойн хооронд, хүзүүний 4-6-р нугалмын харалдаа, хүзүүний өмнөд хагаст
- E. Хэлэн доорхи ясны доор, хүзүүний 3-5-р нугалмын харалдаа

/89./ Доорхи эмгэгүүдээс дуу сөөдөг эмгэгүүдийг ол

- 1. Вирусийн шалтгаант цочмог ларингит
- 2. Дууны хөвчийн зангилаа
- 3. Папилломатоз
- 4. Төвөнхийн гаж хөгжил
- 5. Дууны хөвчүүдийн саа

/90./ 69 настай эрэгтэйн тохой, өвдөгний арьсан дээр, чихний дотор талын арьсан дээр том гүвдрүүт боргоцой шиг ургацтай. Гүвдрүүг хаглахад аарц шиг цагаан зүйл гарна. Өвдөгний үеэр явахад өвддөг тул өвдөлт намдаахаар Ибупрофен уусан ба эмчид хандсан. Түүний шээсний шинжилгээнд оксалат, урат зэрэг давс ихээр илэрсэн. Түүнд ямар өвчин байх магадлал өндөр байна.

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/91./ 72 настай эмэгтэй ханиад туссан ба ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Тэр шээс задгайрлыг эмчлэх хагалгаанд орохыг зөвшөөрөөгүй. Өрхийн эмч түүний амьдралын чанарыг хэрхэн дээшлүүлэх вэ?

- 1. Ханиадыг боломжийн хэрээр хурдан эмчлэх
- 2. Паракоденк эсвэл кодеин 6 -8 цагаар 1-5 хоног уухыг зөвлөнө.
- 3. Уух шингэний хэмжээг багасгах ба шаардлагатай үедээ нэг удаагийн живх хэрэглэж байхыг зөвлөнө.
- 4. 2 цаг тутам шээж, давсгаа суллахыг зөвлөнө
- 5. Орой унтахын өмнө Амитриптиллин ууж байхыг зөвлөнө

/92./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 80 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- A. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай боловч өвчний зарим шинжүүд илэрсэн.
- C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг
- E. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа

/93./ Настангийн төвийн хараа муудахаас сэргийлж өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

- 1. Тамхины хэрэглээг зогсоох
- 2. Наранд удаан гарахгүй байх ба нарны өөдөөс харахгүй байх
- 3. С аминдэмийг 500 мг-аар хоногт уух
- 4. E аминдэмийн 400 ОУН-ээр хоногт уух

5. А аминдэм 5000 нэгжээр ба бета Каротенийг 15 мг-аар уух /*/ ба цинк, зэс зэрэг микроэлементтэй иж бүрдэл хэрэглэх

/94./ Ревматоид артрит нь ихэнхидээ цочмог эхлэлтэй байдаг бөгөөд гэнэт шөнөдөө хуруунууд хавдах, өвдөх зовиур илэрдэг байна.

/95./ РА-ийн үеийн хожуу үед илрэх рентген шинж

1. Үений бүтцийн эвдрэл
2. Буруу байршил үүсэх
3. Анкилоз
4. Үений завсар нарийсах
5. Үений захын мөгөөрсний доорхи шалбархай

/96./ Олон үений үрэвсэлд аль нь илүү тохиолдох вэ:

1. Тулай
2. РА
3. Ясны хавдар
4. Өсвөр насны нуруу барьцалдуулах өвчин
5. Заг хүйтний үений үрэвсэл

/97./ Эрхтэн тогтолцооны хатуурлын эмнэлзүйд аль нь багтдаг вэ:

1. Арьс хатуурах
2. ДВС хам шинж
3. Рейно хам шинж
4. Судас бүдүүрэх
5. Цус алдах

/98./ Хайрст үлдийн үений үрэвслийн үед рентгэнд илрэх өөрчлөлт

1. Үений зай нарийсах
2. Нэвчдэст шалбархай
3. Ясны нягтрал ихсэх
4. Үений гадаргуу хэлбэрээ алдах
5. Мөгөөрсөн доорх уйланхай

/99./ Rheumatoid arthritis хожуу үед рентгэнд илрэх өөрчлөлтийг нэрлэнэ үү.

1. Үений буруу байршил үүсэх
2. Үе мултрах
3. Үений бүтэц эвдрэх
4. Анкилоз
5. Ясны шалбархай

/100./ Шоберын сорилоор нурууны аль түвшинд тэмдэглэгээ хийх вэ?

- A. L3-L5
- B. Th5-Th7
- C. L5-S1
- D. L4-S1
- E. Th11-L3

Сорилын зөв хариулт

1-B, 2-B, 3-A, 4-A, 5-A, 6-C, 7-A, 8-D, 9-D, 10-E, 11-E, 12-E, 13-A, 14-D, 15-E, 16-C, 17-B, 18-A, 19-C, 20-B, 21-B, 22-A, 23-B, 24-B, 25-D, 26-E, 27-C, 28-D, 29-C, 30-A, 31-A, 32-D, 33-A, 34-A, 35-E, 36-B, 37-B, 38-E, 39-D, 40-A, 41-B, 42-E, 43-C, 44-D, 45-C, 46-E, 47-B, 48-E, 49-A, 50-D, 51-D, 52-E, 53-B, 54-D, 55-D, 56-E, 57-C, 58-A, 59-D, 60-C, 61-B, 62-B, 63-D, 64-B, 65-C, 66-B, 67-C, 68-D, 69-C, 70-A, 71-B, 72-B, 73-E, 74-E, 75-D, 76-A, 77-E, 78-A, 79-C, 80-B, 81-D, 82-C, 83-C, 84-E, 85-E, 86-C, 87-A, 88-D, 89-E, 90-D, 91-E, 92-B, 93-E, 94-E, 95-E, 96-C, 97-B, 98-B, 99-E, 100-C,